



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/308

Чингис хот

Коронавируст (Ковид-19) халдварын эмчилгээний  
тоног төхөөрөмжөөр хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Политехник коллежид 100 ор дэлгэж, эмчилгээ үйлчилгээнд нэн шаардлагатай хүчил төрөгч өтгөрүүлэгч аппарат, хяналтын монитор худалдан авах санхүүжилтийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосугай.

2. Дээрх зардалд шаардлагатай 14,100,000 (арван дөрвөн сая нэг зуун мянга)-н төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны хандивын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгө зарцуулах тооцоог хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011663

06 Аймгийн Засаг даргын 2021 оны  
... дугаар сарын ... өдрийн ...  
дугаар захирамжийн хавсралт



НЭН ШААРДЛАГАТАЙ ХҮЧИЛ ТӨРӨГЧ ӨТГӨРҮҮЛЭГ, ХЯНАЛТЫН  
МОНИТОРЫН ЗАРДЛЫН СУДАЛАА

№	Шаардлагатай зүйлс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	ш	5	1,170,000	5,850,000
2	Монитор	ш	5	1,260,000	6,300,000
3	НӨАТ	10%		1,410,000	1,410,000
4	Замын зардал				540,000
Нийт					14,100,000